



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЭРДЭНЭС МЕТАН ХХК-ИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/68/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Энхдалай
Утас: 261885 Цахим хаяг: enkhdalai.d@audit.mn
Аудитор: М.Лхагвасүрэн
Утас: 261740 Цахим хаяг: lkhagvasuren@audit.mn
Аудитыг гүйцэтгэсэн: "Голден пэйж Аудит" ХХК
Гүйцэтгэх захирал: С.Оюунгэрэл
Утас: 99170900 Цахим хаяг: info@goldenpageaudit.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	7
3. Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл	8
3.2 Дотоод хяналт.....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	8
3.4 Материаллаг байдал.....	8
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	9
4.1 Байгууллагын үйл ажиллагаа	9
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	9
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	10
4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	11
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
5.1 Шилэн дансны мэдээлэл	11
5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	12
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
8. Аудитын илрүүлэлт.....	13
8.1 Төлбөрийн акт.....	13
8.2 Албан шаардлага	13
8.3 Зөвлөмж	14
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
АМГТГ	Ашигт малтмал газрын тосны газар

1.Аудитын санал дүгнэлт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 01573
танай _____-ны № _____-т

ЭРДЭНЭС МЕТАН ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.АМАР
ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Метан ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Эрдэнэс Метан ХХ-ийн 2022 оны 12 сарын 31-ны өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Монгол улсын Засгийн газрын 143 дугаар тогтоолоор эрх олгосны дагуу АМГТГ болон Эрдэнэс Метан ХХК-ийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх шилжүүлэхтэй холбоотой татвар нь (ААНОАТ авлагын үлдэгдэл) татварын тайлан, мэдээгээр 275.1 сая төгрөгийн илүү төлөлттэй, холбогдох орлого эх үүсвэр тодорхойгүй, түрээсийн зардалд нийт 53.1 сая төгрөгийн илүү зардал гаргасан зэрэг нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.2, 14.4.5, 20 дугаар зүйлийн 20.2.5 зэрэг хуулийн заалтуудтай нийцээгүй байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Байгууллага нь нийт зардлыг 625.6 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 415.5 сая төгрөгийн санхүүгийн зардал, 220.7 сая төгрөгийн санхүүжилтийн зээлийн хүүгийн зардал гарган 636.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

\\10.10.10.20\Bichig_kheregi\Yawsan_Bichig\2022\0315 Audit\in 2 Gazar - 53.Docx

7001050982

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд үйл ажиллагааны 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 60 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	8,961,891.86	179,134.68
1.1.2	Дансны авлага	535,233.95	330.00
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	343,291.94	343,291.94
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	5,157,260.28	521,822.28
1.1.10	Эргэлтийн хөрөнгийн дүн	<u>14,997,678.03</u>	<u>1,044,578.90</u>
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	20,931,675.24	12,783,330.94
1.2.2	Биет бус хөрөнгө	1,320,000.00	1,320,000.00
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	139,848,400.00	139,848,400.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	472,362,899.00	472,362,899.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	<u>634,462,974.24</u>	<u>626,314,629.94</u>
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	<u>649,460,652.27</u>	<u>627,359,208.84</u>
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	472,614,906.07	20.20
2.1.1.2	Цалингийн өглөг	45,609.03	45,609.03
2.1.1.3	Татварын өр		3,999.32
2.1.1.4	НДШ-ийн өглөг	51.83	51.84
2.1.1.6	Хүүний өглөг	168,854,393.72	220,737,458.37
2.1.1.12	Богино хугацаат өр төлбөрийн дүн	<u>641,514,960.65</u>	<u>220,787,138.76</u>
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	1,654,262,505.47	2,216,730,399.19
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	<u>1,654,262,505.47</u>	<u>2,216,730,399.19</u>
2.2	Өр төлбөрийн нийт дүн	<u>2,295,777,466.12</u>	<u>2,437,517,537.95</u>
2.3	2. Эзэмшигчдийн өмч		
2.3.1	Өмч : а) төрийн	1,000,000.00	1,000,000.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	34,000,000.00	506,362,899.00
2.3.10	Хуримтлагдсан ашиг	(1,681,316,813.85)	(2,317,521,228.11)
2.3.10.1	Тайлангийн үеийн	(520,781,959.94)	(636,204,414.26)
2.3.10.2	Өмнөх үеийн	(1,160,534,853.91)	(1,681,316,813.85)
2.3.20	Эзэмшигчдийн өмчийн дүн	<u>(1,646,316,813.85)</u>	<u>(1,810,158,329.11)</u>
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧИЙН ДҮН	<u>649,460,652.27</u>	<u>627,359,208.84</u>

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12 сарын 31	2021 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)		
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)	-	-
5	Хүүгийн орлого	171,168.04	
10	Ерөнхий ба удирдлагын зардал	347,450,817.46	415,466,955.89
11	Санхүүгийн зардал	168,854,393.72	220,737,458.37
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(4,630,800.00)	
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(520,764,843.14)	(636,204,414.26)
19	Орлогын татварын зардал	17,116.80	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(520,781,959.94)	(636,204,414.26)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(520,781,959.94)	(636,204,414.26)
24	Орлогын нийт дүн	-	-
25	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д.д	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,000,000.00	34,000,000.00	(1,160,534,853.91)	(1,125,534,853.91)
2	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(520,781,959.94)	(520,781,959.94)
3	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,000,000.00	34,000,000.00	(1,681,316,813.85)	(1,646,316,813.85)
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(636,204,414.26)	(636,204,414.26)
5	Бусад дэлгэрэнгүй орлого		472,362,899.00		472,362,899.00
6	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,000,000.00	506,362,899.00	(2,317,521,228.11)	(1,810,158,329.11)

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн	-	-
1.2	Мөнгөн зарлагын дүн	352,345,251.52	375,703,434.53
1.2.1	Ажиллагчдад төлсөн	150,934,374.98	203,204,938.38
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	45,826,449.55	64,096,757.43
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	8,985,788.58	16,062,312.00
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	80,000.00	
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	18,178,717.62	21,609,882.72
1.2.9	Бусад мөнгөн зарлага	128,339,920.79	70,729,544.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(352,345,251.52)	(375,703,434.53)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн	321,215.04	14,000.00
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	150,047.00	14,000.00
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	171,168.04	
2.2	Мөнгөн зарлагын дүн	10,589,760.00	6,784,800.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		5,284,800.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	10,589,760.00	1,500,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(10,268,544.96)	(6,770,800.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн	484,779,250.00	393,613,500.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	484,779,250.00	393,613,500.00
3.2	Мөнгөн зарлагын дүн	113,971,600.00	19,922,022.65
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	113,971,600.00	19,922,022.65
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	370,807,650.00	373,691,477.35
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	8,193,853.52	- 8,782,757.18
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	768,038.34	8,961,891.86
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,961,891.86	179,134.68

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/Мянган төгрөг/

Д.д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Б	Үндсэн үйл ажиллагааны зардал	мян.төг	337,620.0	625,596.0	397,506.9	228,089.1	63.5
1	Үндсэн цалин	мян.төг	189,990.0	252,000.0	251,965.2	34.8	100.0
2	ЭМНД Шимтгэл	мян.төг	23,960.0	34,020.0	33,597.6	422.4	98.8
3	Бичиг хэрэг	мян.төг	2,870.0	7,101.0	2,612.4	4,488.6	36.8
4	Шатахуун, шатах тослох материал	мян.төг	7,210.0	14,800.0	5,500.0	9,300.0	37.2
5	Засварын зардал	мян.төг	2,190.0	3,000.0	286.9	2,713.1	9.6
6	Гадаад албан томилолт	мян.төг	-	24,640.0	-	24,640.0	-
7	Дотоод албан томилолт	мян.төг	9,990.0	42,720.0	1,500.0	41,220.0	3.5
8	Машин түрээсийн зардал	мян.төг	7,530.0	80,000.0	13,800.0	66,200.0	17.3
9	Шуудан, харилцаа холбоо, илгээмж явуулах- дээж	мян.төг	4,360.0	4,510.0	3,869.7	640.3	85.8
10	Хэвлэл захиалга	мян.төг	240.0	730.0	-	730.0	-
11	Хангамжийн материал	мян.төг	2,700.0	7,195.0	4,343.3	2,851.7	60.4
12	Сургалтын зардал	мян.төг	2,160.0	10,000.0	885.9	9,114.1	8.9
13	Мэдээлэл, зар сурталчилгаа	мян.төг	-	12,100.0	-	12,100.0	-
14	Гэрээт ажлын хөлс	мян.төг	6,980.0	22,000.0	4,000.0	18,000.0	18.2
15	Хурал зөвлөгөөн, уулзалтын зардал	мян.төг	8,650.0	15,800.0	5,250.0	10,550.0	33.2
16	Түрээсийн зардал	мян.төг	60,000.0	66,780.0	66,025.0	755.0	98.9
17	Ажилчдын эрүүл мэндийн даатгал	мян.төг	-	8,000.0	-	8,000.0	-
18	Спорт арга хэмжээ ажилчдын нийгмийн асуудалд	мян.төг	-	12,200.0	-	12,200.0	-
19	Эрсдлийн сан	мян.төг	-	8,000.0	3,870.9	4,129.1	48.4
20	Бусад зардал	мян.төг	8,800.0	-	-	-	-
В	Хөрөнгө оруулалтын зардал	мян.төг	26,590.0	15,865.0	5,669.8	10,195.2	35.7
1	Тавилга, эд хогшил	мян.төг	5,810.0	4,095.0	2,394.8	1,700.2	58.5
2	Компьютер, компьютерын дагалдах хэрэгсэл	мян.төг	18,400.0	9,600.0	2,890.0	6,710.0	30.1
3	Биет бус хөрөнгө	мян.төг	2,390.0	2,170.0	385.0	1,785.0	17.7
	Нийт зардал	мян.төг	364,210.0	641,461.0	403,176.7	238,284.3	62.9

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэс Метан ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал, аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны баримт, түрээсийн зардал, ААНОАТ авлага, шилэн данс, зориулалт бус зарцуулалттай холбоотой өгсөн зөвлөмж, албан шаардлага, актыг тусгасан болно.

Аудитыг Голден пэйж Аудит ХХК-ийн аудитор Б.Барбаатар, шинжээч Б.Ариунтуяа, Ц.Цацрал нар гүйцэтгэж, чанарын хяналтыг гүйцэтгэх захирал С.Оюунгэрэл, чанарын хяналтын менежер Б.Дашням нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэс Метан ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Голден пэйж Аудит”ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 01/09 дугаар албан бичгээр хугацаа хоцроож ирүүлсэн.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компани нь Эрдэнэс Монгол ХХК-ийн бодлогын баримт бичгийг мөрддөг тус баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Эрдэнэс Метан ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт хөрөнгийн 649.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 12.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Эрдэнэс Метан ХХК-ийн зорилго нь “Монгол орны хэмжээнд метан хийг олборлож ашигласнаар байгаль орчинд ээлтэй экологийн цэвэр эрчим хүчний эх үүсвэр бий болгоход” оршино.

Эрдэнэс Метан ХХК-ийн дүрэмд үйл ажиллагааны үндсэн чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Уламжлалт болон уламжлалт бус газрын тосны хайгуул судалгаа хийх
- Газрын тостой холбоотой үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт татах
- Үндсэн үйл ажиллагаатай холбоотой тээвэрлэлт
- Газрын тосны хайгуул, судалгаа, тээвэрлэлт болон бусад үйл ажиллагаатай холбоотой бизнесийн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагаа.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд хязгаарлагдмал хариуцлагатай компани статустай байна. Төрийн 100 хувийн өмчит буюу Эрдэнэс Монгол ХХК эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Эрдэнэс Метан ХХК нь Эрдэнэс Монгол ХХК-ийн 2016 оны 02 сарын 02-ны өдрийн төлөөлөн удирдах зөвлөлийн 03 дугаарыг тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Эрдэнэс Метан ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн дүрмийн 5.1 “Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг толгой компани хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу Эрдэнэс Монгол ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл нь ажиллаж байна Эрдэнэс Метан ХХК-аас төлөөлөн удирдах зөвлөлийн цалин гардаггүй байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд ямар нэгэн арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг

өөрчлөөгүй, орон тоог бууруулаагүй, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан тогтоогоогүй, хурал уулзалт, шатахуун, сургалтын зардлыг хэмнээгүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд голлон мөрдөх дараах хууль, тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт орсон. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Эрдэнэс Метан ХХК-ийн санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	8,961.9	179.1	(8,782.8)
Авлага	535.2	0.3	(534.9)
Татвар, НДШ-ийн авлага	343.3	343.3	-
Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	5,157.3	521.8	(4,635.4)
Үндсэн хөрөнгө	20,931.7	12,783.3	(8,148.3)
Биет бус хөрөнгө	1,320.0	1,320.0	-
Урт хугацаат хөрөнгө оруулалт	139,848.4	139,848.4	-
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	472,362.9	472,362.9	-
Нийт хөрөнгийн дүн	649,460.7	627,359.2	(22,101.4)
Өр төлбөрийн дүн	2,295,777.5	2,437,517.5	141,740.1
Богино хугацаат өглөг	641,515.0	220,787.1	(420,727.8)
Урт хугацаат өглөг	1,654,262.5	2,216,730.4	562,467.9
Эздийн өмч	- 1,646,316.8	- 1,810,158.3	(163,841.5)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	649,460.7	627,359.2	(22,101.4)

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 0.2 сая төгрөг болж буурсан нь санхүүжилт буурснаас шалтгаалжээ.

Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл 0.5 сая төгрөг болж буурсан нь тайлант онд ажлын гүйцэтгэлийг дүгнэн зардал хүлээн зөвшөөрснөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 12.8 сая төгрөг болж буурсан нь шинээр тавилга, эд хогшилд 2.4 сая төгрөг, компьютер, дагалдах хэрэгсэлд 2.9 сая төгрөгөөр худалдан авсантай холбоотойгоор нэмэгдэж, хуримтлагдсан элэгдэл 13.4 сая төгрөгөөр байгуулж элэгдлийн зардалтай холбоотой байна.

Богино хугацаат өглөг дансны үлдэгдэл 220.8 сая төгрөг болж буурсан нь 220.7 сая төгрөгийн зээлийн хүүгийн өр төлбөр нэмэгдэж, 472.6 сая төгрөгийн өр төлбөрийг эздийн өмчийн бусад хэсэгт шилжүүлж, 168.9 сая төгрөгийн өр төлбөрийг урт хугацаат өр төлбөрт шилжүүлснээс шалтгаалжээ.

Урт хугацаат өглөг дансны үлдэгдэл 2,216.7 сая төгрөг болж нэмэгдсэн нь үйл ажиллагааны зардлын санхүүжилт болон өмнөх оны зээлийн хүүгийн зардлыг хуримтлуулан бүртгэж тайлагнаснаас шалтгаалжээ.

Кассанд 1.6 сая төгрөг орсон 1.7 сая төгрөг гарсан 0.03 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байна.

Банк дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд байгаа 0.1 сая төгрөг байна.

Эздийн өмчийн дансны үлдэгдэл -1,810.2 сая төгрөг болж 163.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны үйл ажиллагааны алдагдал болох 636.2 сая төгрөгөөр буурч эздийн өмчийн бусад хэсэгт 472.3 сая төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Эрдэнэс Метан ХХК нь үйл ажиллагаа болон санхүүгийн төлөвлөгөөгөө боловсруулж 100.0 хувийн хувьцаа эзэмшигч болох Эрдэнэс Монгол ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрдэнэс Монгол ХХК нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 05 дугаар тогтоолоор Эрдэнэс Метан ХХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт зардлыг 641.5 сая төгрөгөөр тогтоосон байна.

2021 онд эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг тодотгоогүй байна.

Гүйцэтгэлээр 397.5 сая төгрөгийг үйл ажиллагааны зардал, 5.7 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын зардал гарган, нийт 403.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 403.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 238.3 сая төгрөг буюу 62.9 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь Ковид цар тахлын улмаас гадаад болон дотоод албан томилолт, машин түрээс, мэдээлэл зар сурталчилгааны зардал хэмнэгдсэнээс гол нөлөө үзүүлсэн байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Эрдэнэс Метан ХХК нь тайлант онд нийт 179.8 сая төгрөгийн 174 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1 мэдээллийг хоцроож, 3 мэдээлэл 48.6 сая төгрөгийн мэдээллийг байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Эрдэнэс Метан ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг 2022.02.18-ны өдөр 01/09 дугаартай албан бичигтэй хугацаа хоцроож ирүүлсэн, 2022.02.21-ны өдөр тайланг дахин засварлаж ирүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 8.9.8.Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх гэж заасныг зөрчсөн алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалган үзэхэд дараах байдалтай байна.

Нийт 14.8 сая төгрөгийн үр ашиггүй, үрэлгэн зардал гарган зарцуулсан байна. Үүнд:

- Сургалтын зардалд 1 хүний 0.4 сая төгрөгийн магистрын сургалтын зардал төлсөн, тус ажилтан нь сургалтын төлбөр төлүүлж сургасан боловч ажлаас чөлөөлөгдсөн,
- Үйл ажиллагаа явагдаагүй байхад зөвлөх авч ажиллуулсан 3.0 сая төгрөг зарцуулсан,
- Тээврийн хэрэгсэлгүй, шатахууны зарцуулалтын тооцоо хийгээгүй, жолоочийн замын хуудас хөтлөөгүй юунд хэрхэн ашигласан нь тодорхойгүй 5.9 сая төгрөгийн шатахууны зардал гаргасан байна,
- Хурал уулзалтын зардалд 5.4 сая төгрөгийн зардал гаргасан.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.5 "салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомж болон Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол зэрэгтэй нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар алдаа, зөрчил илрүүлээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 148.4 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 310.9 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгснөөс албан шаардлага 100 хувь, зөвлөмж 50 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган

төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	1	148,400.0	1	148,400.0	-		100.0
Зөвлөмж	4	310,900.0	2	100.0	2	310,800.0	50.0
Нийт дүн	5	459,300.0	3	148,500.0	2	310,800.0	80.0

Эрдэнэс Метан ХХК нь өмнөх оны түрээсийн зардал, ААНОАТ-ын авлагатай холбоотой зөвлөмжүүдийг давтан гаргасан тул асуудалд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрдэнэс Метан ХХК-ийн Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаал, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт зэргийг тус тус дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 332.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 0.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 328.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 3.3 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 332.3 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 12.4 сая төгрөгийн материаллагийн түвшнээс 319.9 сая төгрөгөөр их байгаа тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

8.1 Төлбөрийн акт

Батлагдсан төсөвт зардлаас 0.2 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.2 Төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх; 16.5.5 "Төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй," гэсэн тус тус заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

8.2 Албан шаардлага

1. Түрээсийн зардалд 135 м.кв талбайтай оффисын өрөөг сарын 5.0 сая төгрөгөөр түрээсэлж ТӨБЗГ-ын дундаж үнээс 35.7 сая төгрөгөөр илүү зардал гаргасан, байгууллага тээврийн хэрэгсэлгүй боловч зогсоолын түрээс 3.6 сая төгрөг төлсөн, машины түрээсийн зардалд 13.8 сая төгрөг нийт 53.1 сая төгрөгийн илүү зардал гаргасан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2-т "төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах ...", Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," гэж заасныг хэрэгжүүлээгүй өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Монгол улсын Засгийн газрын 2020 оны 04 сарын 22-ны 143 дугаар тогтоолоор эрх олгосны дагуу АМГТГ болон Эрдэнэс Метан ХХК-ийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх шилжүүлэхтэй холбоотой татвар нь (ААНОАТ авлагын үлдэгдэл) Монголын татварын албаны мэдээгээр 275.1 сая төгрөг илүү төлөлттэй байна. Энэ нь холбогдох орлого эх үүсвэр тодорхойгүй, тайлагнагдаагүй байна. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4. "нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:" 14.4.2. "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.5-д "бүх орлого", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэсэн хуулийн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн оршин байх "Санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, өр төлбөр тухайн аж ахуйн нэгж байгууллагад бодитой оршин байх", эрх ба үүрэг "Санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, өглөг уг аж ахуй нэгж байгууллагад хамааралтай, эзэмших, бүртгэх эрхтэй, өр төлбөрийг төлөх үүрэгтэй

байх" гэсэн батламж мэдэгдлийг мөрдөөгүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

3. Мөнгөн хөрөнгийн түүврээр Цахим баримтын бүрдэлд нийт зардлын 0.7 сая төгрөгийн худалдан авалтын цахим баримтыг бүрдүүлэн ажиллаагүй, өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6 "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын зэрэг заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

8.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Анхан шатны баримтын бүрдэл дутуу 3.3 сая төгрөгийн гүйлгээ хийсэн байна. Кассын тайлан дээр хянасан нягтлан бодогчийн гарын үсэг байхгүй, кассын орлого, зардлын баримт хүчингүй болсон маягтаар хөтөлсөн, дарга, нягтлан бодогч, хүлээлгэн өгсөн хүний гарын үсэггүй, санхүүгийн тамгагүй, бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг хүчин төгөлдөр маягтаар хөтлөх, иж бүрдлийг ханган ажиллах, бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлэн ажиллах.

2. Тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн тайланг хүчингүй болсон маягтын дагуу тайлагнасан, 2021 оны санхүүгийн тайланг 2022.02.18-ны өдөр 01/09 дугаартай албан бичигтэй хугацаа хоцроож ирүүлсэн байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг хүчин төгөлдөр маягт, зааврын дагуу гаргаж тайлагнах, хуульд заасан цаглабрын дагуу тайланг гаргаж хүргүүлдэг байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15

№ 80/А 0150053

Улаанбаатар хот

АХГ-2022/68/НА-СТА-ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Метан ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан төсөвт зардлаас 196,885.00 төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.2 "Төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх", 16.5.5 "Төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.2.3.7 "төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг дутаасан, үрэгдүүлсэн, хууль бусаар ашигласан; гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Батлагдсан төсөвт зардлаас 196,885 (нэг зуун ерэн зургаан мянга найман зуун наян таван) төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот төгрөгийн дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрдэнэс Метан ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Амар, нягтлан бодогч Д.Саран нарт хариуцуулав.

АКТ ТОГТООСОН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ХЭЛТСИЙН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
С.ОЮУНГЭРЭЛ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-244230

\\10.10.10.20\share_kh\temp\Akr\2022\03\13\Audit 2\Gaar-89.Docx

001090245



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 401/А0150053
АХГ-2022/68/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Метан ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 143 дугаар тогтоолоор эрх олгосны дагуу Ашигт малтмал, газрын тосны газар болон Эрдэнэс Метан ХХК-ийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх шилжүүлэхтэй холбоотой татвар нь (ААНОАТ авлагын үлдэгдэл) Монголын татварын албаны мэдээгээр 275,080,100 төгрөг илүү төлөлттэй боловч санхүүгийн тайланд тусгаагүй, холбогдох орлогын эх үүсвэр тодорхойгүй байна. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 "нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2 "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.5 "бүх орлого", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" санхүүгийн тайлангийн "оршин байх", "Санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, "өр төлбөр тухайн аж ахуйн нэгж байгууллагад бодитой оршин байх", эрх ба үүрэг "Санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, өглөг уг аж ахуй нэгж, байгууллагад хамааралтай, эзэмших, бүртгэх эрхтэй, өр төлбөрийг төлөх үүрэгтэй байх" гэсэн батламж мэдэгллийг мөрдөөгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох албан шаардлага өгөхөд баримтлах" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Ажил, гүйлгээг үнэн зөв бүртгэж, нягтлан бодох бүртгэлд тусгаж байх, холбогдох стандарт, хууль, журам, зааврыг мөрдөж ажиллах, алдаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Метан ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Амар, нягтлан бодогч Д.Саран нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ХЭЛТСИЙН ЗАХИРАЛ, Ц.НАРАНЧИМЭГ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР, Д.ЭНХДАЛАЙ
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ С.ОЮУНГЭРЭЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, "Бага" тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-74230

АХГ-2022/68/НА-СТА-ТӨА

0010801162



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 402/16.0150053

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Метан ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийт 14,760,271 төгрөгийн үр ашиггүй, үрэлгэн зардал гаргасан байна. Үүнд:

- Сургалтын зардалд 1 хүний 414,300 төгрөгийн магистрын сургалтын зардал төлсөн, тус ажилтан нь сургалтын төлбөр төлүүлж сурсан боловч ажлаас гарсан;
- Үйл ажиллагаа явуулан хэрэгжээгүй байхад зөвлөх авч ажиллуулан 3,000,000 төгрөг зарцуулсан;
- Тээврийн хэрэгсэлгүй, шатахууны зарцуулалтын тооцоо хийгээгүй, жолоочийн замын хуудас хөтлөөгүй, юунд хэрхэн ашигласан нь тодорхойгүй 5,912,093 төгрөгийн шатахууны зардал гаргасан.
- Хурал уулзалтын зардалд 5,433,878 төгрөгийн зардал гаргасан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2 "төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах ...", Төсвийн тухай хуулийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.5 "салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх" зэрэг заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө. Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох албан шаардлага өгөхөд баримтлах" журмын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Ажил, гүйлгээг үнэн зөв бүртгэж, зардлыг хэмнэх, холбогдох стандарт, хууль, журам, зааврыг мөрдөж ажиллах, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Метан ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Амар, нягтлан бодогч Д.Саран нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ХЭЛТСИЙН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГОЛДЕН ПЭИЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
С.ОЮУНГЭРЭЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 11-р хороо, Бага тэжүүр-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-74230

0010801166



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№: 403/А/0150053

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Метан ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 474,578,500.00 төгрөгийн ажил, гүйлгээний 174 мэдээлэл байршуулахаас 48,567,500.00 төгрөгийн ажил, гүйлгээний 3 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө. Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Метан ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Амар, нягтлан бодогч Д.Саран нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
 АУДИТЫН ХОЁРДУГААР ХЭЛТСИЙН ЗАХИРАЛ,
 ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
 АУДИТЫН МЕНЕЖЕР
 ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
 ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
 Д.ЭНХДАЛАЙ
 С.ОЮУНГЭРЭЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
 Утас 51-204230

\\10.10.10.20\backlog_khreeg\Alban_Shaardlaga\2022\03\15_Audit_2_Gazar-00.Docx

0010801164



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 404/А/0156053
АХГ-2022/68/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Эрдэнэс Метан ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Мөнгөн хөрөнгийн түүврээр нийт 665,052.00 төгрөгийн худалдан авалтын цахим баримтыг бүрдүүлэн ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6 "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө. Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох албан шаардлага өгөхөд баримтлах" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Цахим баримтгүй ажил, гүйлгээг бүртгэхгүй, санхүүгийн тайланд тусгахгүй байх, зөрчлийг арилгаж, холбогдох хууль дүрмийг мөрдөн ажиллаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Метан ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Амар, нягтлан бодогч Д.Саран нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ХЭЛТСИЙН ЗАХИРАЛ, *Б.М.* НАРАНЧИМЭГ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Д.Э.* ХДАЛАЙ
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ *С.О.* ЮНГЭРЭЛ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

10.10.10.20\Nchlg_Ahreg_Alban_Shaardlaga-2022\0315_Audit_2_Gazra-02.Docx

0010801168



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 405/А.0150053

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Эрдэнэс Метан ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Оффисын түрээсийн зардалд 135 м.кв талбайтай өрөөнд сарын 5,000,000.00 төгрөг буюу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоосон жишиг үнээс нийт 35,700,000 төгрөгөөр илүү зардал гаргасан, байгууллага тээврийн хэрэгсэлгүй боловч зогсоолын түрээс 3,600,000.00 төгрөг, машины түрээсийн зардалд 13,800,000.00 төгрөг, нийт 53,100,000.00 төгрөгийн илүү зардал гаргасан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2 "төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах ...", Төсвийн тухай хуулийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө. Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох албан шаардлага өгөхөд баримтлах" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Түрээсийн зардлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын жишиг үнээс хэтрүүлэхгүй байх, машины түрээс, зогсоолын түрээсийн зардлыг хэмнэх, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Метан ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Амар, нягтлан бодогч Д.Саран нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ХЭЛТСИЙН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

С.ОЮУНГЭРЭЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тосгуу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-204230

И/О.19.10.2020/Аг_Эхрэг/Албан Шаардлага/2022/03/3 Аудит 7 Газр-88.Docx

0010831160

